

Зорилго

Бэлчээрийн үр ашигтай, тогтвортой менежментийг боловсруулах, хэрэгжүүлэх замаар малчдын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ядуу болон эмзэг бүлгийн малчдын бие даасан байдлыг бэхжүүлэх.

Зорилтууд

Зорилт-1. Бэлчээр сайжруулах, тэжээл үйлдвэрлэх зохистой технологийг туршиж малчдын хүртээл болгох.

Үр дүн: Тослийн 1-р шатанд Монгол орны бэлчээрийн доройтол, түвнийг нохон сэргээх чиглэлээр хийсэн туршилтууд нь Монгол оронд бэлчээрийн чиглэлийн судалгаа шинжилгээг сэргээхэд түлхэц огч, шинэ хандлага, жишгийг бий болгосон тодийгвй бэлчээрийн менежментийн талаар хийсэн чанар сайтай, системчилсэн судалгааны цорын ганц эх сурвалж болж байна.

Туршилтын гол үр дүн бол их доройтсон бэлчээрийг нохон сэргээх нь бэрхшээлтэй, ортог ондортэй, эрсдэлтэй, харин бэлчээрийг доройтохоос урьдчилан сэргийлэх, хэт доройтохоос омо шаардлагатай арга хэмжээ авах нь хамгийн найдвартай арга гэдгийг харуулсан явдал юм. Малчид эдгээр хээрийн туршилт судалгааны дүнтэй танилцаад бэлчээрийг сэлгэж, онжоож амрааж ашиглахын чухлыг хүлээн зовшоорч эхэлсэн болно.

Зорилт-2. Малчид, орон нутгийн удирдлага, бусад талуудын оролцоон дээр түшиглэсэн бэлчээрийн хамтын менежментийн зарчмыг сонгосон сумдад хэрэгжүүлэх.

Үр дүн: Бэлчээрийн доройтлын үндсэн шалтгааны нэг нь 1990 оны эдийн засгийн шилжилтээс хойш нийтийн эзэмшлийн бэлчээрийг дур зоргоор ашиглаж, малын тоо толгой хэт оссоноор, бэлчээрийн даац хэтэрсэн явдал юм. Бэлчээр ашиглалтыг тороос зохицуулах эрхзүйн зохицуулалт, тосов, ажиллах хүчин дутмаг байгаа нь гол бэрхшээл болж байна.

Дэлхий нийтийн практикаас үзэхэд нийтийн омчийн нооцийг (ой, бэлчээр, загас, ус, агаар) дур зоргоор ашигласнаар хэтрүүлж цолмоход хүргэж байна. Үүнийг зогсоох нэг арга нь түвнийг бүрэн хувьчлах явдал мон боловч, энэ нь бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг Монгол орны хувьд тохиромжгүй арга юм. Ногоон алт төслийн баримталж байгаа зарчим нь нутаг дэвсгэрт тулгуурласан малчдын хамтын үйл ажиллагаагаар бэлчээрийн зохистой менежментийг хэрэгжүүлэх ажлыг дэмжих явдал юм. Энэ зарчмын цом нь Бэлчээр ашиглагчдын хэсгүүд (БАХ)-ийг байгуулахад оршино. Тухайн орон нутагт малчдын нүүдэллэж, мал аж ахуйгаа хотлон явуулж ирсэн уламжлалыг эвдэлгвйгээр хил хязгаарыг тогтоон БАХ-үүдийг байгуулах богоод энэ хил хязгаарт амьдарч буй малчин орхүүд тухайн хэсэгт нэгдэн зохион байгуулагдах юм. БАХ-үүд бэлчээрийг улирлаар сэлгэн, онжоож амраах, нүүдэллэх, бэлчээрийн менежментийн технологи, зохион байгуулалтын бусад арга хэрэгслийг дэмжиж ажиллана. БАХ -үүдийн боловсруулсан Бэлчээрийн менежментийн толовлогоо сумын Бэлчээрийн менежментийн толовгооний

вндэс болох богоод тvvнийг сумын Иргэдийн толоологчдийн хуралд оргон барьж батлуулна. БАХ-вvd бие даасан этгээд боловч орон нутгийн засаг захиргааны дэмжлэгт тvшиглэж ажиллах юм.

Тослийн эхний шатанд байгуулагдсан БАХ-вvdийн вйл ажиллагаа бэлчээрийг тогтвортой ашиглах толовлогоог боловсруулан хэрэгжvvлэхэд малчид оролцож чадахыг, тусгай хууль эрх зvйн зохицуулалтаар малчдын оорийгоо удирдах байгууллага цаашид хогжин дэгжих боломж байгааг илтгэн харуулсан юм.

Зорилт-3. Бэлчээр сайжруулах, бэлчээрийн хамтын менежементийг хэрэгжvvлэх хууль эрх зvйн орчин бvрдvvлж, туршин харуулах.

Үр дvн: Бэлчээр ашиглалтыг зохицуулах, зохион байгуулахад малчдын оорийгоо удирдах байгууллагыг байгуулах нь зvй ёсны хэрэг боловч, бэлчээр ашиглах эрх мэдэл, vvрэг хариуцлага, хяналт, эзэмшлийн хэр хэмжээ ямар байхыг албан ёсоор заасан эрх зvйн зохицуулалт тодорхойгvй, Бэлчээрийн асуудлыг зохицуулсан тусгай хууль байхгvй зэрэг нь дээрх вйл ажиллагаануудыг хязгаарлагдмал байдалд оруулж байна. Засгийн газрын хоронго нооц хязгаарлагдмал байхад хууль эрх зvйн орчныг бvрдvvлэхэд ихээхэн хугацаа орно. Тиймээс Ногоон алт тосол энэ чиглэлээр УИХ-ын Байгаль орчин, хvнс, ходоо аж ахуйн байнгын хороо, Хvнс, ходоо аж ахуй, хонгон вйлдвэрийн яам, Газрын харилцаа, барилга, геодези, зураг зvйн газар, аймгуудын засаг даргын тамгын газар зэрэг газруудтай хамтран ажиллаж, 1-р шатандаа хэрэгжvvлсэн ажлын туршлагадаа тулгуурлан "Бэлчээрийн тухай хууль"-ийн тослийг боловсруулан орон даяар хэлэлцvvлж, УИХ-д оргон бариад байна.

Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн толовлогоо хийх аргачлалыг ГХБГЗЗГ, НҮБХХ болон Бодлого Судлалын Товтэй хамтран боловсруулж, ГХБГЗЗГ батлан гаргав. Энэ аргачлал бэлчээрийн толовлолт, менежментэд оролцох малчдын хамтын нийгэмлvvдийн хувьд вндэсний хэмжээний стандарт болов. Малчдын байгууллагууд хогжихийн хэрээр улс орон даяар малчид, орон нутгийн засаг захиргаатай хамтран бэлчээрийн газрын толовлолтод оролцох хvчирхэг хорс суурь бий боллоо.

Нэгдүгээр ve шат хэрэгжсэн газрууд:

- Бэлчээр сайжруулах болон технологийн туршилт, судалгааны ажлууд явуулсан газрууд:
- Архангай аймгийн Их Тамир сум
- Сэлэнгэ аймгийн Шаамар сум
- Тов аймгийн Аргалант сум
- Тов аймгийн Борнуур сум
- Тов аймгийн Баянчандмань сум

Малчдын өөрийгөө удирдах байгууллагыг байгуулан, бэлчээрийн хамтын менежментийг туршин хэрэгжvvлсэн сумд:

- Архангай аймгийн Их Тамир сум
- Дундговь аймгийн Олзийт сум
- Баян-Олгий аймгийн Цэнгэл сум
- Завхан аймгийн Тэлмэн сум
- Төв аймгийн Ондорширээт сум

Хэрэгжүүлэгч:

"Ногоон Алт"; Тослийг Дэмжих Нэгж

Төсөв:

4.5 сая CHF (швейцарь франк)

Санхүүжүүлэгч:

Швейцарийн Хөгжлийн Агентлаг